

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2009 он 11 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 21.

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Үнэт цаасны зах зээл дээр брокер дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулж байгаа “Бидисек” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын нэг болох “Монбайгаль” ХХК нь тусгай зөвшөөрөлгүйгээр андеррайтерийн үйл ажиллагаа эрхэлсэн эсэх, эрхэлсэн гэж үзвэл тухайн үйл ажиллагааны орлого болох холбогдох хөрөнгийг “Бидисек” ХК-д шилжүүлсэн эсэх, түүнээс зохих татварыг төлсөн эсэх тухай асуудлыг Үнэт цаасны газрын дарга Э.Ганбат танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Бидисек” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын дээрх заалтын биелэлтийг хэлэлцэв.

1. “Монбайгаль” ХХК нь татварын албанд зохих татварыг төлсөн гэж өмнөх Хорооны хуралд танилцуулж, гишүүдэд буруу мэдээлсэн тул үнэт цаасны газрын ахлах байцаагчийн шийдвэрээр торгуулийн арга хэмжээ авахаар тогтов.

2. “Монбайгаль” ХХК-ийг тусгай зөвшөөрөлгүйгээр андеррайтерийн үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үндэслэл хангалтгүй байгаа, мөн тус компани нь **566 619 746,75** төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаж, ногдох татвараа нөхөн төлсөн, дээрх орлогоос өмнөх 3 жилд тухай бүр үйл ажиллагаандаа зарцуулсан байгаа зэргийг харгалзан үзэж “Бидисек” ХК-ийн орлогоор тооцож тус компанийн дансанд оруулах боломжгүй гэж тогтов.

3. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, аливаа шинэ харилцааг төлөвшүүлэх, зохицуулагдаагүй асуудлаар шийдэл гаргахдаа урьдчилж тус Хороонд мэдээлэн ажиллахыг “Бидисек” ХК /Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн/-д үүрэг болгохоор тогтов.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН